



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ*

2018 оны 6 дугаар сар


Ерөнхий тойм: Энэ оны эхний 6 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 26%-иар буюу 1,304 сая ам.доллараар өсч 6,341 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 15%-иар буюу 476 сая ам.доллараар, импорт 43%-иар буюу 829 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлсөн байна. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 353 сая ам.доллараар буурч 822 сая ам.долларын ашигтай байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 6 сар			Өөрчлөлт			
	2015	2016	2017	2016/2015		2017/2016		2016	2017	2018	2017/2016		2018/2017	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	8,467	8,274	10,536	(192)	-2%	2,262	27%	3,692	5,036	6,341	1,344	36%	1,304	26%
Экспорт	4,669	4,916	6,201	247	5%	1,284	26%	2,193	3,106	3,581	913	42%	476	15%
Импорт	3,798	3,358	4,335	(439)	-12%	977	29%	1,499	1,931	2,759	431	29%	829	43%
Тэнцэл	872	1,558	1,865	686		307	20%	694	1,175	822	481	69%	(353)	-30%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл 2018 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 221 сая ам.доллараар буурч 1,019 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/



Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 67% буюу 4,238 сая ам.долларын худалдааг БНХАУ улстай, 14% буюу 859 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 54%-иар, БНХАУ-тай хийсэн худалдаа 25%-иар тус тус өссөн байна.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Гадаад худалдааны нөхцөлийн индекс 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс 17%-иар өссөн хэдий ч өмнөх сараас 3%-иар буурч 2.021-д хүрлээ. Худалдааны нөхцөл өмнөх сараас муудахад тайлант сард чулуун нүүрсний экспортын үнэ буурсан, машин механик, тоног төхөөрөмжийн импортын үнэ өссөн зэрэг нь голлон нөлөөлөв.

* Энэхүү тоймыг ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.

Экспорт 2018 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 15%-иар буюу 476 сая ам.доллараар өсөв. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өссөн нь нийт экспортыг 14 нэгж хувиар өсгөх чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 0.5 нэгж хувиар өссөн бол аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 0.6 нэгж хувиар буурсан байна.

Хүснэгт 3. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2016			2017			2018			Δ (2017/2016)			Δ (2018/2017)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²
1. Уул уурхай		1,880	86%	2,729	88%		3,165	88%		849	45%	39%	436	16%	14.0%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	821	920	42%	733	765	25%	734	1,014	28%	(156)	-17%	-7%	249	33%	8%
1.2. Чулуун нүүрс	9,678	295	13%	18,957	1,278	4%	18,024	1,405	39%	982	333%	45%	127	10%	4%
1.3. Боловсруулаагүй нефть	4,179	160	7%	3,720	182	6%	3,299	212	6%	22	4%	1%	30	17%	1%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	2,587	98	4%	2,689	159	5%	3,373	156	4%	60	61%	3%	(3)	-2%	0%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	7,074	280	13%	4,471	180	6%	3,432	144	4%	(100)	-36%	-5%	(36)	-20%	-1%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	68	72	3%	58	86	3%	62	108	3%	14	19%	1%	22	25%	1%
1.7. Жонош, лейцит, нефелинт	119	27	1%	143	34	1%	196	64	2%	7	25%	0%	30	87%	1%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	3	12	1%	3	16	1%	3	23	1%	4	37%	0%	6	37%	0%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	1	4	0%	0	2	0%	0	2	0%	(2)	-61%	0%	1	0%	0%
1.10. Мөнгө /тонн/	22	9	0%	0	0	0%	0	0	0%	(9)	-97%	0%	0	0%	0%
1.11. Бусад	46	1	0%	200	26	1%	260	35	1%	25	20x	1%	9	36%	0%
2. Мал аж, ахуй	116	190	9%	226	7%		235	269	8%	36	19%	2%	43	19%	1.4%
2.1. Амьд мал, малын мах	2	5	0%	6	10	0%	11	24	1%	5	103%	0%	14	138%	0%
2.2. Арьс, шир	103	17	1%	167	14	0%	212	11	0%	(2)	-14%	0%	(3)	-21%	0%
2.3. Малын өлөн гэдэс	0	4	0%	0	4	0%	0	4	0%	(0)	-5%	0%	0	0%	0%
2.4. Ноолуур	5	156	7%	6	191	6%	7	222	6%	34	222%	2%	31	16%	1%
2.5. Ноос, бусад үс, хялгас	5	8	0%	4	6	0%	4	7	0%	(2)	-24%	0%	0	8%	0%
2.6. Бусад	0	0	0%	1	1	0%	1	1	0%	1	229%	0%	(0)	-8%	0%
3. Газар тариалан	97	11	1%	89	6	0%	12	3	0%	(6)	-51%	0%	(3)	-49%	-0.1%
4. Аж үйлдвэрлэл	119	111	5%	261	145	5%	159	144	4%	34	31%	2%	(0)	0%	0.0%
4.1. Хүнс	3	16	1%	12	53	2%	12	35	1%	37	228%	2%	(18)	-34%	-1%
4.2. Ноолууран эдлэл	0	7	0%	0	8	0%	0	10	0%	1	9%	0%	2	33%	0%
4.3. Бусад хувцас, пүтэл, эдлэл	1	6	0%	1	5	0%	2	6	0%	(0)	-7%	0%	0	8%	0%
4.4. Уул уурхай	12	33	2%	18	53	2%	29	57	2%	20	60%	1%	3	6%	0%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	0	0%	0	1	0%	0	2	0%	0	6%	0%	1	215%	0%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	1	44	2%	1	22	1%	2	33	1%	(22)	-51%	-1%	11	50%	0%
4.7. Бусад	103	4	0%	230	3	0%	15	3	0%	(1)	-19%	0%	(0)	-12%	0%
5. Бусад	0	1	0%	1	0	0%	0	0	0%	(0)	-20%	0%	0	1%	0.0%
Нийт дүн		2,192		3,106			3,581			913	42%		476	15%	

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 4. Экспортын өөрчлөлт, 2018 оны 6 дугаар сар

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	Үнийн	%	Нийт	%
1. Уул уурхай	(79)		515		436	16%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	1	0%	248	100%	249	33%
1.2. Чулуун нүүрс	(73)	-57%	200	157%	127	10%
1.3. Боловсруулаагүй нефть	(27)	-89%	57	189%	30	17%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	32		(34)		(3)	-2%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	(44)	122%	8	-22%	(36)	-20%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	7	32%	15	68%	22	25%
1.7. Жонош, лейцит, нефелинт	18	58%	12	42%	30	87%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	(1)	-24%	8	124%	6	37%
1.11. Бусад	8	87%	1	13%	9	36%
2. Мал аж, ахуй	54		(11)		43	19%
2.1. Амьд мал, малын мах	11	76%	3	24%	14	138%
2.2. Арьс, шир	2	-79%	(5)	179%	(3)	-21%
2.3. Малын өлөн гэдэс	0	202%	(0)	-102%	0	0%
2.4. Ноолуур	40	129%	(9)	-29%	31	16%
3. Газар тариалан	(18)		15		(3)	-49%
4. Аж үйлдвэрлэл	41		(41)		(0)	0%
5. Бусад	(0)		0		0	1%
Нийт дүн	(3)		479		476	15%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



2018 оны эхний 6 сард экспортын гадаад худалдааны тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 3 сая ам.доллараар буурсан бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 479 сая ам.доллараар өссөн байна. Чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ буурснаас шалтгаалж 72 сая ам.доллараар буурсан хэдий ч үнийн өсөлтөөс шалтгаалж 448 сая ам.доллараар өссөн байна. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ өссөнөөс шалтгаалж 41 сая ам.доллараар өссөн боловч үнийн өөрчлөлтөөс шалтгаалан 41 сая ам.доллараар буурсан байна.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2018 оны 6 дугаар сард 1,280 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 2%-иар өссөн бол өнгөрсөн сараас 1.8%-иар буурсан байна. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 6,966; 65 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 22%-иар, төмрийн хүдэр 13%-иар тус тус өссөн бол өнгөрсөн сараас зэс 2.1%-иар өсч, төмрийн хүдэр 1.6%-иар буурсан байна. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 6 дугаар сард 77 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 15%-иар өсч, өмнөх сараас 2.4%-иар буурсан байна.

Импорт 2018 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 43%-иар буюу 829 сая ам.доллараар өссөн. Импортын өсөлтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 22 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүн болон нефтийн бүтээгдэхүүний өсөлт тус бүр 7 нэгж хувийг, аж үйлдвэрийн орц бүтээгдэхүүний өсөлт 6 нэгж хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 5. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2016			2017			2018			Δ (2017/2016)			Δ (2018/2017)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²
Хэрэглээний бүтээгдэхүүн		540	36%		602	31%		746	27%	62	11%	4%	144	24%	7%
Түргэн эдлэгтэй	365	280	19%	424	328	17%	460	395	14%	48	17%	3%	67	21%	3%
Хүнс	189	192	13%	179	228	12%	224	273	10%	36	19%	2%	45	20%	2%
Эм, тариа	1	42	3%	1	42	2%	1	55	2%	(0)	-1%	0%	14	33%	1%
Бусад түргэн эдлэгтэй бараа	175	45	3%	244	58	3%	235	66	2%	13	28%	1%	8	14%	0%
Удаан эдлэгтэй	66	261	17%	107	274	14%	106	351	13%	14	5%	1%	76	28%	4%
Гутал, хувцас, цүнх	25	23	2%	31	27	1%	27	34	1%	4	16%	0%	7	28%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	11	51	3%	40	41	2%	42	53	2%	(10)	-19%	-1%	12	29%	1%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	0	156	10%	1	174	9%	1	225	8%	17	11%	1%	52	30%	3%
Бусад удаан эдлэгтэй бараа	30	31	2%	35	33	2%	36	39	1%	2	7%	0%	5	16%	0%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	593	503	34%	551	722	37%	817	1,155	42%	220	44%	15%	432	60%	22%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	7	283	19%	11	472	24%	15	742	27%	189	67%	13%	269	57%	14%
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	0	72	5%	0	122	6%	1	236	9%	50	70%	3%	114	93%	6%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	7	211	14%	11	350	18%	14	506	18%	139	66%	9%	156	44%	8%
Барилгын материал	358	131	9%	268	172	9%	353	312	11%	41	31%	3%	140	82%	7%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	22	88	6%	32	78	4%	22	101	4%	(10)	-11%	-1%	23	29%	1%
Аж үйлдвэрлэлийн орц	419	261	17%	612	248	13%	734	366	13%	(13)	-5%	-1%	119	48%	6%
Хүнсний орц	155	41	3%	20	9	0%	257	67	2%	(31)	-77%	-2%	58	619%	3%
Химийн бүтээгдэхүүн	62	41	3%	84	49	3%	96	58	2%	8	20%	1%	9	18%	0%
Даавуу, утас, арьс, савжин эдлэл	10	9	1%	20	11	1%	36	14	1%	2	21%	0%	4	35%	0%
Цахилгаан эрчим хүч	1	61	4%	1	63	3%	1	71	3%	2	3%	0%	8	12%	0%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	1	1	0%	1	0	0%	0	0	0%	(0)	-59%	0%	0	39%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	364	108	7%	425	115	6%	426	155	6%	6	6%	0%	40	35%	2%
Нефтийн бүтээгдэхүүн	419	194	13%	612	355	18%	734	488	18%	161	83%	11%	133	38%	7%
Дизель түлш	211	86	6%	369	197	10%	392	253	9%	111	129%	7%	57	29%	3%
АИ-92, АИ-95	152	72	5%	168	101	5%	181	113	4%	29	41%	2%	12	11%	1%
А-80 болон бусад	56	36	2%	76	57	3%	161	122	4%	21	59%	1%	65	114%	3%
Бусад	3	2	0%	8	4	0%	141	4	0%	2	99%	0%	0	14%	0%
Нийт дүн		1,499		1,931			2,759			431	29%		829	43%	

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 6. Импортын өөрчлөлт, 2018 он

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	65	0	79	1	144	0
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	246	1	187	0	432	1
Аж үйлдвэрлэлийн орц	47	0	72	1	119	0
Нефтийн бүтээгдэхүүн	88	1	46	0	133	0
Дизель түлш	15	0	42	1	57	0
АИ-92, АИ-95	8		3		12	0
А-80 болон бусад	65		(3)		65	1
Бусад	4		0		0	0
Нийт дүн	449	1	380	0	829	0

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2018 оны эхний 6 сарын гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 432 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 144 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 133 сая ам.доллараар, аж үйлдвэрлэлийн орц бүтээгдэхүүний импорт 119 сая ам.доллараар өссөнөөр нийт импорт 829 сая ам.доллараар өссөн байна.

Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2018 оны 6 дугаар сард өмнөх сараас 3 хувиар, өмнөх оны мөн үеэс 27 хувиар тус тус өсч тонн тутамд 697 ам.долларт хүрэв.